



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Ажлын цагийг зохицуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/217 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1, Хөдөлмөрийн дотоод журмын 5.5, Газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн 9 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачаалал болон албан хаагчдын оршин суух байршлыг харгалзан албан хаагчдын ажил, амьдралын тэнцвэрийг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын цагийг уян хатан байдлаар зохицуулсугай.

2. Ажлын цагийг (2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн) ажил 08:00-08:30 цагт эхэлж, 17:00-17:30 цагт дуусдаг байхаар өөрчлөн тохируулсугай.

3. Ажлын байранд ажиллах 8 цагийг өндөр үр бүтээлтэй ажиллаж, гүйцэтгэсэн ажлаа тухай бүр тайлагнаж ажиллахыг нийт албан хаагчдад, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т тус тус даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ